

8

АЖИЛГҮЙДЭЛ, ИНФЛЯЦИЙН ХАМААРАЛ

Д. Намсрай

Макро эдийн засгийн бодлого нь цөөн үзүүлэлтээр эдийн засгийг хянан зохицуулах боломж өгдөг. Энэхүү үзүүлэлтэд ажилгүйдэл, инфляци хоёр чухал байр эзлэж байна. Нийт эрэлтийн тэлэх ба агших үед ажилгүйдэл, инфляци хоёрын мэдрэмж өндөр байдаг нь нэг талаас нийт эдийн засагт зохицуулалт хийхэд хэмжүүр болж нөгөө талаас хүн амын хөдөлмөр эрхлэлт, цалин, пүүсийн орлого түүний үр ашиг здгэрээр дамжин салбарын хөгжлийн асуудалд ч нөлөө үзүүлдэгээрээ эдийн засгийг макро болон микро түвшинд өөрчлөж чаддаг байна.



Өнөөдөр нээлттэй эдийн засаг бодит байдал, шаардлага болж нэг улс орны асуудал ч нийт дэлхийн зах зээлтэй гарцаагүй холбогдож эхэлжээ. Чухам ийм болохоор бид гадагш хандсан, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг шүтэж, валютийн нөөцийн асуудал бидний амьдралд чухал нөлөө үзүүлсээр байна. Өнөөдрийн байдлаар бидний мэдэлд байгаа (бид өртэй учраас энэ нь харьцангуй ойлголт юм) манай улсын валютийн нөөц 100.0 сая ам. доллар орчмоор хэмжигдэж тэр нь үнэн хэрэгтээ эдийн засагт инфляцийг намдуу байлгахад чухал хэрэгсэл болоод байна. Хүн амын амьжиргааны түвшин угаас доогуур манай орны хувьд ажилгүйдэл бодит байдал дээр 20 хувь хүрсэн нь хүн амын орлого хэрэглээг туйлын ядуу төвшинд байлгаж багаахан хөрөнгөөр инфляцийг дараад байх боломжийг бидэнд өгч байна. Өнгөрсөн хугацаанд Монгол банкнаас үе үе хийж байсан интервенцээс харахад л энэ нь ойлгогдоно. Энэ нь цаад утгаараа ажилгүйдэл их байвал инфляци бага байх боломж өгдөг эдийн засгийн бодит зүй тогтол дээр үндэслэж байгаа хэрэг юм.

Эдийн засгийн урт хугацааны зорилт нь хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээг аль болох зохистой хангах, чадавхит үндэсний орлогод хүрэх явдал мөн. Харин богино хугацааны үед боломжит үндэсний орлогын түвшинг зорилго болгож чадавхит үндэсний орлогод шат дараалан ойртох хэрэгтэй болдог. Ямар түвшинг боломжит үндэсний орлогын түвшин гэж үзэх вэ гэдэг нь макро эдийн засгийн

үзүүлэлтүүдийн зохистой уялдаа холбоо тэр тусмаа инфляци ажилгүйдэл хоёрын холбоо хамаарал дээр ихээхэн тулгуурладаг билээ.

Филипсийн муруй: Эдийн засгийн чухал зангилаа асуудлынхаа хувьд ажилгүйдэл, инфляцийн холбоо хамаарал, тэдгээрийн макро ба микро түвшин, урт ба богино хугацааны үе дэх үйлчлэлийн талаар эрдэмтэд эдийн засагчид олон талаас нь авч үздэг бөгөөд өнөө хир онолын бүхэл бүтэн зөвшилцэлд хүрээгүй гэж үзэж байна. Ахь онолын үндсийг нь тавьсны хувьд Филипсийн муруй хэмээн нэрлэгдсэн ч энэ онолд олон эрдэмтэн хувь нэмрээ оруулжээ. Дүгнээд үзвэл өөр өөрийн онолын баримтлалаар олон талаас нь шүүмжлэх бас нотлохыг эрмэлздэг ажээ. Филипс, Липсей, Фридман, Феллс, Лукас, Гордон, Алчиан, Саржент зэрэг олон эрдэмтэд энэ асуудлыг судлаж түүгээр ч барахгүй Самуэльсон, Солоу нар эдийн засгийн бодлого боловсруулахад Филипсийн муруйг ашиглахыг зөвлөж байсан. Өөрөөр хэлбэл, эдийн засаг бүхэлдээ ажилгүйдэл, инфляцийн харилцан солилцоо, солбилцол дээр оршиж байна. Филипсийн муруйн дагуухүү цэг бүр нь эдийн засгийн бодлогын хөтөлбөрийн нэг хувилбарыг агуулж байна. Эдийн засгийн бодлого боловсруулагчид ажилгүйдэл, инфляцийн түвшний хосполуудаас сонголт хийх ажлыг Филипсийн муруй хөнгөвчлөнө гэж үзэж байгаа хэрэг юм. Гэхдээ эдийн засаг тогтвортгуй нөхцөлд байвал Филипсийн муруйг ашиглах нь тийм ч найдвартай биш гэж үздэг. Учир нь энэ үед төрөөс эдийн засгийг зохицуулах оролдлого их байдгаас зах зээлийн үнийн механизмын үйлчлэл жаягаараа явагддаггүй нь нөлөөлдөг. Филипсийн муруйн чухал агуулга нь таамаглаж буй инфляци ба таамаглаагүй инфляцийн тухай ойлголт юм. Филипсийн муруйг үзэх эрдэмтэдийн үзэл бодлын зөрөө нь энэ асуудалтай ихээхэн холбоотой байна. Тухайлбал, оновчтой хүлээлтийн онол баримтлагчид нь таамаглаагүй инфляцийн тухай ойлголтыг үгүйсгэдэг. Өөр нэг зүйл бол Филипсийн муруйн богино ба урт хугацааны тухай ойлголт мөн. Эрдэмтэд Филипсийн муруйн богино хугацааны үйлчлэлийн талаар санал нэгтэй байдаг. Харин урт хугацаанд үйлчлэнэ гэдэг дээр бүрэн санал нийлэхгүй байна. Филипсийн муруй дээрхи ажилгүйдэл, инфляци хоёр зэрэг өсөх нөхцлийг эрдэмтэд үзэхдээ муруй бүхэлдээ баруун дээш шилжилт хийж байгаа хэрэг гэж түүнийг урт хугацааны өөрчлөлт хэмээн үзэх явдал байдаг. Филипсийн муруйн тухай эрдэмтдийн үзэл бодлыг нэгтгэн дүгнэвэл ийм байна. Харин одоо Филипсийн муруйн ерөнхий дүрслэл дээр түүний богино хугацааны үйлчлэлийг аваад үзье (дүрслэл 1, дүрслэл 2). Энэ нь үйлдвэрлэл, үнэ, нийт эрэлтийн түвшин, ажилгүйдэл, инфляци гэсэн макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн холбоо хамаарлыг харуулж, эдийн засгийн бодит хууль, зүй тогтолын илэрхийлэл болдог. Дүрслэл 1-ээс бид нийт эрэлт (AD)-ийн өсөлтийн зэрэг хэдий хир их байвал үнэ (P) төдий хир ихэсч, үйлдвэрлэлийн бодит хэмжээ (Q) төдий хэмжээгээр багасч ийм болохоор ажилгүйдэл ч энэ хэмжээгээр ихсэх зүй тогтолтойг харж болно. Эсрэг тохиолдолд хэрэв нийт эрэлт аажим хурдаар өсвөл үнийн өсөлт намдуу байж, бодит бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт түүний нэрлэсэн хэмжээнээс илүү өсөлттэй байх болно. Эндээс инфляцийн өндөр хурдац ажилгүйдлийн доогуур түвшинг дагуулах боломжтой (дүрслэл 2) нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн хэлс өндөр байх нь инфляцийг өсгөх нэг талын

Дүрслэл 1: Үнэ, үйлдвэрлэлийн бодит хэмжээ

Дүрслэл 2. Филипсийн муруй:
ажилгүйдэл инфляцийн хамаарал:


Манай орны хувьд ажилгүйдэл инфляци хоёрын хооронд ямар хамаарал байгааг авч үзье (Хүснэгт 1, дүрслэл 3). 1991 онд манай үндэсний мөнгөн тэмдэгтийн масштабыг 2 дахин нэмэгдүүлж, зарим бүтээгдэхүүний үнийг шат дараалан шалтгаан болно л гэсэн үг юм. Эндээс үзвэл макро эдийн засагт сонголтын хоёр туйл байж болох бөгөөд эсвэл өндөр инфляци (I) ба нам ажилгүйдэл (U) эсвэл намдуу инфляци өндөр ажилгүйдэл гэсэн хувилбарууд байна. Энэ хоёрын завсар мэдээж бусад хувилбарууд буюу дээр бидний хэлсэн эдийн засгийн бодлогын бусад хувилбарууд байна гэсэн үг. Бодит амьдрал дээр ч мөн л жолоодлогогүй инфляцаас сэргийлэхийн тулд эрэлтийг хязгаарлах замаар бид орлогын өсөлтийг сааруулдаг нь хөдөлмөр эрхлэлтийг бууруулж, ажилгүйдлийг өсгөдөг. Учир нь эрэлтийг тэлснээр ажилгүйдлийг багасгах арга хэмжээ нь дараачийн шатандыа инфляцийг 2 дахин өсгөх (богино хугацаанд) нөлөөтэй байдаг. Ийм учраас өндөр инфляцийг үүсгэхгүй байх, нийт эрэлтийг тогтооходоо инфляцитай холбон үзэх нь ажилгүйдлийг бодвол нилээд чухал асуудал болдог. Тухайлбал, улс орны эдийн засгийн тэнцэл нь нийт эрэлтийг зохицуулах мөнгөний бодлогоор дамжин инфляцийг багасгахыг

чөлөөлж эхэлснээр манай эдийн засаг өөрийн жинхэнэ чадавхит хөрсөн дээрээ бууж эхэлсэн. 1992 онд инфляцийн хамгийн огцом өсөлт болж 325.5 хувьд хүрч энэ үед ажилгүйдэл хуучин тогтолцооны үед 3 хувь байсан бол 6.3 хувь болж мөн л өсөв.

Хүснэгт 1

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
Инфляци	54.4	325.5	183	66.3	53.1	44.6	20.5	6	10
Ажилгүйдэл	6.5	6.3	8.5	8.7	5.4	6.5	7.5	5.8	4.6

Дүрслэл 3. Албан бүртгэлтэй ажилгүйдэл ба инфляцийн хамаарал



Өсөлтийн динамикаар бол инфляци ажилгүйдэл хоёр 1989-1992 онд зэрэг өссөн байна. Өөрөөр хэлбэл Филипсийн муруй баруун дээш шилжилт хийсэн байна. Харин цар хэмжээний талаас нь аваад үзвэл шилжилтийн эхний энэ үед манай хуучин тогтолцооны аж ахуйн систем задарч амжаагүй хөдөлмөр эрхлэлтийн түвшин үндсэндээ хэвээр байсан болохоор ажилгүйдлийн төвшин бага байсан юм. Өөрөөр хэлбэл энэ үеийн ажилгүйдэл инфляцийн харьцаа 6.3:325.5 байжээ. Энэ үед авсан арга хэмжээг зөв буруу гэж дүгнэхийг урьдал болголгүйгээр хэлэхэд л бүтээгдэхүүний үнийг чөлөөлөх, мөнгөний масштабыг өөрчлөх зэрэг нь инфляцийг өсгөх хүчин зүйл учраас тэр нөлөөгөө л үзүүлжээ. Зах зээлийн эдийн засагт шилжих гэдэг нь шууд утгаар үнэ чөлөөлөлт мөн гэвэл инфляци өсөх нь манай орны хувьд гарцаагүй байсан байж болно. Харин дараачийн үе шатанд өндөр инфляцийн үр нөлөөгөөр аж ахуйн үйл ажиллагааны сүйрлийн үе байх нь (гадны ямар нэгэн

томоохон тусламж дэмжлэг байхгүй бол) гарцаагүй байлаа. Үүний эцсийн үр дүнд үндэсний үйлдвэрүүдийн дампуурал, ажилгүйчүүдийн арми түүнээс үүдэн гарсан ядуурал – материаллаг болон оюуны хомсдол газар авч байна. Харин нэгэнт ядуурсан, олон хүн ажилгүй болсон улсын хувьд инфляцийг зохицуулахад хялбар байдаг ажээ. Өнөөдөр инфляцийг зохицуулах гол судас нь хүн амын өргөн хэрэглээний 205 нэрийн бүтээгдэхүүний үнэ болж байна. Энэ нь ч олон улсын стандартаар тийм билээ. Харин эдгээр бүтээгдэхүүний хангамжид нөлөөлж, үнийг нь хөөрөгдөх хэмжээгээр эрэлт нийлүүлэлтэд нөлөөлөхүйц худалдан авах чадвар манай ядуу хүн амд байхгүй байгаа нь манай онцлог мөн. Манай улсын 3 өрх тутмын нэг нь Засгийн Газраас баталсан амьжирааны баталгаат доод түвшин (АБДТ)-өөс доогуур амьдарч байна. Гэтэл АБДТ гэдэг маань өчүүхэн түвшин гээд бодохоор хүн ам нийтдээ ядууралд өртөөд байна. Эндээс бид хөгжлөөр дорой, ядуу буурай орны хувьд өндөр ажилгүйдэл, намдуу инфляцийн хамаарал хэрхэн нөлөөлдгийг харж болно.

Ажилгүйдэл өнөөдөр ямар түвшинд хүрснийг аваад үзье.

Албан бүртгэлтэй ажилгүйчүүд: Улсын Статистикийн Газрын мэдээгээр манай улсад 1991 оноос хойши хугацаанд хөдөлмөрийн биржид бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо харьцангуй тогтвортой байна (хүснэгт 2).

1993 оноос хойши хугацаанд ажилгүйчүүдийн тоо 60.0 гаруй мянгаас 70.0 гаруй мянгад хэлбэлзэж иржээ. 1995 онд Улсын ажилгүйдэл, ядуурлын үзлэгийг зохион байгуулахдаа ажилгүйдлийн шалгуур үзүүлэлтийг буруу сонгож, хөдөлмөрийн хөлсний баталгаат хэмжээнээс дээш орлого олж байгаа хүмүүсийг хувиараа хөдөлмөр эрхлэж байгаад тооцож хөдөлмөрийн биржийн бүртгэлээс хассанаар ажилгүйчүүдийн тоо энэ онд эрс багасч (45.1) харин бүртгэлгүй хөдөлмөр

Хүснэгт 2

	1993	1994	1995	1996	1997	1998	1999
1. Хөдөлмөрийн насны хүн ам	1133.6	1165.7	1186.7	1212.8	1229.6	1256.8	1279.3
2. Эдийн засгийн идэвхитэй хүн ам: Үүнээс Ажиллагчид Бүртгэлтэй ажилгүйчүйд	844.7	861.4	839.8	847.2	852.9	859.3	869.8
3. Хөдөлмөр эрхлээгүй бүртгэлгүй хүний тоо	772.8	786.5	794.7	791.8	779.2	809.5	830.0
4. Ажиллах хүчиний оролцооны түвшин %	71.9	74.9	45.1	55.4	63.7	49.8	39.8
5. Ажилгүйдлийн түвшин %	288.9	304.5	346.9	365.6	386.7	397.5	409.5
	74.5	73.9	70.8	69.9	69.3	68.4	68.0
	74.5	73.9	70.8	69.9	69.3	68.4	68.0

эрхлээгүйчүүдийн тоо эрс өсөхөд (346.9) хүргэсэн. Үүнээс шалтгаалан 1995, 1996 онд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо багасч гарсан боловч цаашид өсч 70.0 гаруй мянга болон хуучин төвшиндөө хүрсэн юм. 1999 оны байдлаар албан бүртгэлтэй ажилгүйчүүдээр тооцсон ажилгүйдлийн түвшин 4.6 хувь байна.

Хөдөлмөр эрхлээгүйчүүд: Ажиллах хүний оролцооны түвшин 68,0 хувьтай байгаа нь хөдөлмөр эрхлээгүй боловч хөдөлмөрийн биржид бүртгэлгүй хүний тоо их байгааг харуулж байна. Хөдөлмөрийн биржид бүртгүүлээгүй хөдөлмөр эрхлээгүй хүний тоо бүртгэлтэй ажилгүйчүүдээс илүү хурдацтай өсч ирлээ. 1999 оны байдлаар нийтдээ хөдөлмөрийн насны 409.5 мян. хүн хөдөлмөр эрхлээгүй байна. Тэднээс хөдөлмөрийн насны суралцагсад, тахир дутуугийн групптэй хөдөлмөрийн насны хүмүүсийг хасаад албан ёсны зохион байгуулалттай хөдөлмөр эрхлээгүй боловч хөдөлмөрийн биржид бүртгүүлээгүй хүний тоо ойролцоогоор 200 гаруй мянга болж байна. Тэдгээрийг шалтгаанаар нь аваад үзвэл 60-аад хувь нь хүндэтгэх шалтгаантай (өвчтөн асардаг, хүүхэд хардаг г.м.) үлдсэн 40 хувь нь мэргэжлийн ажил олдлогүй, цэргээс халагдсан, сургууль төгссөн, ажил улирлын чанартай зэрэг шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй хүмүүс байна. Бидний явуулсан түүвэр судалгаагаар эдгээр хүмүүс ажил эрхлэх хүсэлтэй байгаа нь харагдсан. Ингээд үзвэл дээрхи хөдөлмөр эрхлээгүйчүүдээс 80.0 гаруй мянга нь ажил эрхлэх хүсэлтэй боловч ажил олдлогүй, гэхдээ албан ёсоор бүртгүүлээгүй хүмүүс байна. Хөдөлмөрийн биржид бүртгүүлээгүй хөдөлмөр эрхлэхгүй байгаа хүний тоо ингэж их байгаа нь нэг талаас мэдээлэл боловсронгуй болж чадаагүй учраас албан бус хөдөлмөр эрхлэлт нилээд байгааг ч харуулдаг талтай. Нөгөө талаас, бүртгүүлсэн ч ажил олдох найдвар муу, хөдөлмөр зохион байгуулалтын албад үүргээ гүйцэтгэх чадвар сул, төлөвшиж чадаагүй байгаатай ч холбоотой байна.

Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт (далд ажилгүйдэл): Манай орны хувьд мал аж ахуй эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг, хөгжлөөр буурай, хүн амын багагүй хувь нь амиа аргацаасан хувийн мал аж ахуйтай болсон, хөлсний хөдөлмөр төдийлөн төлөвшиж чадаагүй байгаа, үндэсний үйлдвэр хүчин чадлаа бүрэн ашиглаж чадаагүй сул зогсолттой байгаа зэрэг олон шалтгаан нь бүрэн бус хөдөлмөр эрхлэлт нилээд хувийг эзлэж ажилгүйдэл далд хэлбэрээр илрэхэд нөлөөлж байна. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн нилээд хувь нь мал аж ахуй дахь малчин өрхийн хэт жижиг аж ахуйд байна. Өмч хувьчлалын явцад манай хөдөө аж ахуйд гарсан өөрчлөлт гэвэл малыг үндсэнд нь хувийн жижиг аж ахуйтанд шилжүүлсэн явдал юм. Мал үндсэндээ хувийн аж ахуйд шилжсэнээр амиа аргацаасан жижиг аж ахуйнууд үүсч, төвлөрсөн хэрэгцээнд өгдөг байсан мал аж ахуйн бүтээгдэхүүн: мах, сүү, цагаан идээ, цөцгийн тосний нийлүүлэлт байхгүй болсон. Мал аж ахуйн бүтээгдэхүүний таваарлаг чанар эрс буурч малчдын орлого биет хэрэглээгээр төлөвшиж байна. Малыг хувьчилснаар өмч эзэндээ ойртсон нь том амжилт болсон боловч нөгөө талаас, төвлөрсөн төлөвлөлтийн үеийн том аж ахуйнууд жижиг аж ахуйн хэвшил болон задарсан нь үйлдвэрлэлийн төрөлжилт таваарлаг чанар хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлжээ. Өнөөдөр малчин өрхийн хөдөлмөрийн орлого нь үндсэндээ малаас авах биет бүтээгдэхүүн боллоо. Энэ нөхцөлд малын тоо хэт

цөөн байх нь тухайн өрхийн хувьд амьжирааны хэрэгцээг хангах төдийд зориулагдаж хэт цөөн мал өсөх боломжгүйгээс аажмаар малгүй болж ажилгүй орлогогүй болоход хүргэж байна. Мэргэжлийн зарим хүмүүсийн хийсэн судалгаагаар нэг өрх 200 толгой малтай болсон тохиолдолд бүтээгдэхүүний таваарлаг чанар хангагдаж, хуримтлалтай болж чадна гэвэл улсын хэмжээнд малчин өрхийн* 10 хүрэхгүй хувь нь энэ шаардлагыг хангаж байна. НҮБ-ын Хүн хөдөө аж ахуйн байгууллагын мэргэжилтнүүдийн судалгаагаар мал аж ахуйгаас өөр амьжирааны эх үүсвэргүй байсан тохиолдолд малчин өрхийн мал өсөх боломж 0.75 гэдэг дүгнэлтийг үндэслэн тооцвол ийм өрх улсын хэмжээнд 35530 байгаа нь 3-4 жилд малгүй, ингэхлээр 166991 хүн амьжирааны эх үүсвэргүй (өрхийн дундаж хүний тоо 4.7-гоор бодвол), 71060 хүн ажилгүй болох нь гэж баримжаалж болох. Үүний нөгөө талд малжих баяжих, хөлсний хөдөлмөр хэрэглэх шаардлага байх нь зүй. Мал өсөхөд олон хүчин зүйл нөлөөлж болох бсловч одоохондоо хүн бүлтэй ажиллах хүч боломжтой айлын хувьд мал өсгөх боломж илүү харагдаж байна. Ийм өрхийн хувьд хүн хүч төдийлөн шаардлагагүй учраас хөлсний хөдөлмөр хэрэглээд байгаа тохиолдол одоогоор бараг байхгүй байсан ч ядарсан ах дүүгээ дагуулж ажилдаа туслуулах хэмжээнд л илэрч байна. Нөгөө талаас нүүдлийн мал аж ахуйд билчээрийн даац нь малын тоо толгойн өсөлтийг хязгаарлах нөлөөтэй. Тэгээд ч хөдөө аж ахуйд хөлсний хөдөлмөр хэрэглэх нь төрөлжсөн том аж ахуйн зохистой хэлбэр байх ёстой гэдэг нь ойлгомжтой. Жижиг аж ахуйн хувьд хөлсний хөдөлмөр хэрэглэдэггүй хэрэглэсэн ч тохиолдоор өдөр цагаар байдаг. Одоогоор мал аж ахуйг хувьчилж нэгэнт хувийн жижиг аж ахуйн хэвшилд шилжсэн ч тэр нь төрөлжсөн үр ашиг, бүтээмжтэй хөдөлмөрийн зохион байгуулалтад орж хөгжих үйл явц удаан байна. Хот айлын зохион байгуулалт, хоршоо, компани, нөхөрлөл гэх мэт яригдавч шалгарч тодорсон нь хараахан угүй байна. Энэ нь хөрөнгө мөнгө, мэдлэг боловсрол зохион байгуулалтын аль ч талаасаа хангалтгүй байна. НҮБ-ийн арга зүйчдээс хөдөөгийн жижиг аж ахуйтны бүрэн бус хөдөлмөр эрхлэлт, далд ажилгүйдэлд хийдэг судалгааны арга зүйг үндэс болгон далд ажилгүйдлийн коэффициентыг тооцвол улсын хэмжээнд 11323 хүн ажилгүй байна гэж үзэж болох. Хэрэв мэргэжлийн зарим хүмүүсийн хэлж байгаагаар хуримтлалтай байхын тулд 200-аас дээш толгой малтай байна гэвэл дээрхи хэмжээ улам өсөх болно. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт нь хувиараа хөдөлмөр эрхлэлтийн бусад хүрээнд, сүл зогсолттой үндэсний үйлдвэрүүдэд ч байна. Манай улсад ажилгүйдлийн дийлэнхи нь ингэж далд хэлбэрээр илэрч байгаа учраас ажлын байрны баталгаа муу, орлогын түвшин доогуур байна. Хэдийгээр далд ажилгүйдлийг хөгжлийн түвшинтэй холбон байх ёстой зүйл мэт үздэг үзэл бодол байдаг ч нөгөө талаасаа бид ядуу буурай орны тооноос гарахыг хүсч байгаа бөгөөд хөгжих нь гарцаагүй зорилго юм бол далд ажилгүйдлийг харин хамгийн түрүүнд шийдвэрлэх ёстой. Эцэст нь бүртгэлтэй ажилгүйчүүд, хөдөлмөр эрхлээгүйчүүд, далд ажилгүйдлийг баримжаалан тооцвол манай улсын ажилгүйдлийн түвшин 20 хувь аль хэдий нь гарчээ. Ингээд үзвэл ажилгүйдэл инфляцийн харьцаа манай оронд 26:7.6 гэсэн тоо гарч байна. Өөрөөр хэлбэл 1992 оны 6.3:325 байсан бол өнөөдөр 26:10 болж нам ажилгүйдэл өндөр

* Нийт малчин өрхөөр тооцов.

инфляци байсан бол өндөр ажилгүйдэл нам инфляцаар солигджээ. Өөрөөр хэлбэл манай эдийн засаг ч инфляци ажилгүйдэл хоёрын харилцан солилцоон дээр байгааг харж болно.

Манай орны хувьд зах зээлийн эдийн засгийн шилжилтийн энэ үед эдийн засагт мэнгэний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийг намдуу байлгах үүднээс хүн амын орлогын доогуур түвшинг чухалчилж ирлээ. Гэвч энэ зорилгыг хэрэгжүүлэх үүднээс нийт эрэлтийг аглаах нь пүүсийн орлогыг ч хязгаарлахад хүргэж аж ахуй эрхлэх боломжийг боогдуулдаг нь харагдаж байна. Учир нь ажилчдын цалин өндөр байх нь аж ахуйн ашиг орлогыг нэмэгдүүлэх чухал хөшүүрэг мөнөөс мөн. Гэвч өнөөдөр аж ахуй эрхлэгчдэд ажилчдаа өндөр цалингаар урамшуулах ямар ч боломж байхгүй байгаа нь татварын болон даатгалын тогтолцооноос харагдаж байна. Зөвхөн нийгмийн даатгалын багц хуулиар гэхэд л ажилчдын цалингийн фондтой шууд хамааралтайгаар аж ахуйн нэгжийн орлогоос 20 гаруй хувийн шимтгэл авч байгаа нь ажилчдын цалинг өсгөх ямар ч сонирхол төрүүлэхгүй байна. Өөрөөр хэлбэл Аж ахуйн нэгжийн эрх ашиг, ажилчдын эрх ашиг хоёр зөрчилдөж байгаа хэрэг. Компани өндөр ашиг олох боломжгүй учраас хангалттай цалин өгч чаддаггүй, цалин урамшуулал болж чаддаггүй учраас ажилчид бүтээлийн хойноос хөөцөлдөггүй, бүтээлгүй учраас пүүс нь орлогоо өсгөх боломжгүй байгаа нь манай аж ахуй эрхлэгчдийн нийтлэг зовлон болжээ. Хэдийгээр аж ахуйн нэгжийн орлогоос татвар, хураамж, шимтгэл авах нь зүйн хэрэг боловч зөвхөн мэнгэний бодлогод захирагдан хүн амын амьдралын түвшин, аж ахуй эрхлэх боломжийг хэт боогдуулж байгаа нь үндэсний орлогын өсөлтийг сааруулж хөгжлийн асуудлыг орхигдуулж байна. Хэдийгээр өндөр инфляци нь илүү аюултай гинжин холбоог үүсгэдэг ч ажилгүйдлээр түүнийг орлуулах гэж хэт шүтэх нь улс орныг ядууралд хөтлөж байгаа хэрэг мөн. Тэгэх тусмаа угаас ядуу буурай орны хувьд инфляцийг дарах зорилгоор нийт эрэлтийг хязгаарлах арга нь ажилгүйдэл ядуурлыг улам гааруулж байна. Ингэснээр хэт унасан эдийн засгаа өөрийн хүчээр сэргээх боломж нь багасч гадаадын зээл тусламжид л найдаахад хүрдэг ажээ. Хөгжил, ядуурал, ажилгүйдэл, инфляци дөрөв хоорондоо эвлэршгүй ажээ. Онолын үүднээс Филиппсийн муруй дээрхи цэг бүр нь ажилгүйдэл инфляцийн хослолын нэг л хувилбарыг хэлдэг бөгөөд эдгээрээс аль зохистойг нь сонгох болохоос аль нэг туйлийг нь сонгох нь эдийн засгийг хэт хялбарчилж байгаа хэрэг юм. Мэдээж энэ ажил нь маш сайн бөгөөд хангалттай мэдээлэлд тулгуурласан ихээхэн хүч хөдөлмөр шаардах нь ойлгомжтой.